



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 11/94

Мандалговь

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дэрэн сумын нутагт гарсан малын гоц халдварт хонины "Цэцэг" өвчиний үед хорио цээрийн дэглэм тогтоох, Сайнцагаан сумын нутагт гарсан малын гоц халдварт үхрийн дуут хавдар өвчний үед шаардагдах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, 2017 оны 03 сарын 22-ноос 24-ний өдрүүдэд Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумдад их хэмжээний цас орж цасан шуурга шуурах үед малчид, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж ажиллахад дээрх сумдаас зарцуулсан нийт шатахууны зардалыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Уг арга хэмжээнд зарцуулсан 2,433,530 /хоёр сая дөрвөн зуун гучин гурван мянга таван зуун гучин төгрөг/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200565